

## Хэсэг 21

# Монголын нийслэлд хэлмэгдүүлэлтийн өмнө болон шашин сэргэсний дараах бурханы шашны зан үйл, баяр ёслол

Кристина Телеки

Монголын Бурханы шашны зан үйлүүд нь Бурханы шашныг түгээн дэлгэрүүлэх, хамаг амьтныг гадаад, дотоод шалтгаанаас үүдэлтэй зовлон зүдгүүр, саад тотгороос ангижруулж, энэ болон хойд насны буян хишгийг арвижуулж, гэгээрэлд хүргэхэд туслан чиглүүлэх зорилгоор сүслэн залбирах үйл юм. Энэхүү илтгэлдээ би 1937 оноос өмнө нийслэл Улаанбаатар хотод болдог байсан, мөн 1990 оноос хойш сэргээн хөгжүүлж буй Бурханы шашны зан үйлүүдийг танилцуулах болно.<sup>1</sup>

### Сүйтгэл ба сэргэн мандалт

Монголд 1930-аад оны сүүлээр шашныг шатлалтайгаар устгаж эхлэхээс өмнө 1000 гаруй сүм, хийд хуралтай байжээ. Эдгээрийн голлох төв болох Өргөө (Их Хүрээ, Даа Хүрээ, Богдын Хүрээ зэрэг нэртэй байсан) нь 1924 он хүртэл Богд хааны (мөн Жавзандамба хутагт буюу төвдөөр *gje btsun dam ra*) өргөө байжээ. 100 гаруй сүм, хийдтэй энэ хүрээнд гэлүгва ёсны (шарын шашны урсгал) ном сургаал давамгайлж байлаа. Зүүн хүрээ 45 орчим сүмтэй, Гандан хийд 10 сүмтэй байснаас гадна хойд хэсэгт хоёр том сүм (Дамбадаржаа, Дашчойнхорлин), мөн бясалгалын нэжгээд сүм (Шадивлин) байжээ. Энгийн ардад үйлчилдэг хэсэгт нь гэлүгва болон нямава (улааны шашны урсгал) ёсны сүмүүд байрлаж байлаа.<sup>2</sup>

<sup>1</sup> Уг өгүүллийг Монголын шашны нийслэл хотын соёлын өвийг баримтжуулах зорилготой ОТКА PD 83465 төслийн хүрээнд бичлээ.

<sup>2</sup> Шашны төв болсон нийслэл хотын сүм, хийдүүдийн талаарх нэмэлт мэдээлэл авахыг

Бурханы шашны зан үйлүүдийн талаар судалгаа шинжилгээ хийхэд А.М.Позднеевын<sup>1</sup> тэмдэглэлүүд, архивын материал, фото зураг болон аман мэдээлэл үнэтэй эх сурвалж болдог. Хурлын гол танхимуудад өдөр бүр хурдаг ном, мөн сар, жилийн давтамжтай үйлддэг шашны баяр ёслолууд нь сүсэгтэн олны амьдралыг идэвхтэй, сонирхолтой болгож байв. 1937 оноос шашны бүх зан үйлийг зогсоожээ. Гандан хийдийг 1944 онд хэсэгчлэн нээсэн ч хуучин зан үйлийн ихэнхийг 1990 оны ардчилсан өөрчлөлт шинэчлэлийн дараа л сэргээх боломжтой болсон юм. Зарим нь 1930-аад оны хэлмэгдүүлэлтийн өмнө сүм хийдэд шавилан сууж байсан, одоо насан өндөр болсон лам нар бурханы шашны ном судар, дуу хөгжим, өргөл барьц болон хийдийн дэг жаягийг залуу лам нарт заан сургаж шашныг сэргээн дэлгэрүүлэхэд гол үүргийг гүйцэтгэсэн юм. Өнөөдөр Улаанбаатар хотод 40 гаруй сүм хийд үйл ажиллагаа явуулж байгаагаас 30 гаруй нь гэлүгва ёсны номлолыг даган мөрдөж байна.<sup>2</sup> Эдгээрээс хамгийн том нь болох Гандан, Зүүн хүрээ Дашчойлин, Бэтүв зэрэг хийдэд шашны олон янзын зан үйл үйлдэгдэж байна. Жижиг сүм, хийдүүд цөөн ламтай, тэдгээрт очдог сүсэгтэн цөөн, өргөл барьц бага, шашны уламжлалыг сэргээх хүн байхгүй тул тийм олон зан үйл үйлдэх боломжгүй юм.

---

хүсвэл [www.mongoliantemples.net/English](http://www.mongoliantemples.net/English) хаягаар байршуулсан Телеки К.: *Богдын хүрээ: Монголын шашны нийслэлийн сүм, хийдүүд (1651-1938). Докторын зэрэг горлох диссертаци, Өтвөш Лоранд Их сургууль, Будапешт хот, 2009* материалыг үзнэ үү.

<sup>1</sup> Pozdneyev, A.M., *Religion and Ritual in Society: Lamaist Buddhism in late 19th-century Mongolia*. редактор Крюгер Ж.Р. Монголын Нийгэмлэг. Блүүмингтон 1978; Pozdneyev, A. M., *Mongolia and the Mongols*, редактор Крюгер Ж.Р., орчуулсан Шоу Ж.Р. Планк О.Д. Блүүмингтон, Индианагийн Их сургууль 1971

<sup>2</sup> Өнөөгийн Улаанбаатар хотын сүм, хийдүүдийн талаар нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл [www.mongoliantemples.net/English](http://www.mongoliantemples.net/English) хаягаар байршуулсан Майер С., *Монголын сүм, хийдүүдийн өнөө үеийн зан үйл, ёслолын харьцуулсан судалгаа. Докторын зэрэг горлох диссертаци, Өтвөш Лоранд Их сургууль, Будапешт хот, 2009* материалыг үзнэ үү.

## Өдөр тутмын ном уншлага, жил бүрийн шашны баяр ёслолуудын түүх, өнөөгийн байдал

Хэдийгээр шашны зан үйл, тэдгээртэй холбоотой нэр томъёо Төвдөд үүссэн ч өдөр тутмын уншлагад хэд хэдэн ном багтдагийн зарим нь Монголын алдартай лам нарын бичиж туурвисан ном байдгаараа Төвдийн зан үйлээс ялгаатай. Өдөр тутмын уншлагыг Монголын бараг бүх сүм хийд сэргээгээд байна.<sup>3</sup> Билгийн тооллын сар бүрийн найман, арван таван болон гучны өдөр нь хуучин хурал номын газруудын чухал зан үйл гүйцэтгэдэг онцлог өдрүүд байсан юм. Өнөөдөр ч сар бүрийн найман, арван таван болон гучны өдөр тогтмол ном хурж байна.

Жилдээ нэг удаа үйлддэг шашны зан үйлүүд нь Өргөө хотод энгийн ард түмнийг хэдэн мянгаар нь татан авчирдаг томоохон баяр ёслол байжээ. Одоо зуны эхэн сард тэмдэглэх болсон Их Майдар эргэх буюу ирээдүйн бурхан Майдарыг хүндэтгэх ёслол (төвдөөр *byams pa*) нь Өргөөгийн хамгийн гайхалтай үйл явдлуудын нэг болдог байсан тухай Позднеев бичсэн байдаг (1971, pp. 54-55.). Уг ёслол нь Майдарын чого буюу Жамбын чого гэж нэрлэгддэг (төвдөөр *byams pa'i cho ga*). Лам, энгийн ардууд бүгд нийлээд, ногоон морин толгойн чимэгтэй аварга тэргэн дээр байрлуулсан Майдар бурханы дүрийн араас цувран дагаж, хийдийн хашааг тойрон явдаг байжээ. Энэ ёслолыг Майдар эргэх гэж нэрлэдэг байв. Майдар бурханд зориулсан өөр нэг ёслол *Майдарын дүйчэн өдөр* нь зуны сүүл сарын 6-нд тохиодог бөгөөд энэ өдөр *Жасаа Жамбын чого* уншдаг байжээ. Өнөөдөр ирээдүйн Бурханы морилон ирэх цагийг түргэтгэхийг билэгддэг энэ номыг Гандан болон Зүүн хүрээ Дашчойлин хийд, зарим олон нутгийн жижиг дацанд уншиж байна.

<sup>3</sup> Зүүн Хүрээний Дашчойлин хийдэд өдөр тутам уншдаг номуудыг 2004 онд хэвлэн гаргасан байна. Б.Жамбал, Д. Мөнхсайхан., *Цогчин уншлагын зэрэг тус амгалан гарахын орон оршвой*. Улаанбаатар 2004

Өөр нэгэн чухал ёслол нь *цам* (төвдөөр ‘*chams*) бүжиг бөгөөд шашны энэ бүжгийг 100 гаруй лам оролцон зуны цагт бүжиглэдэг байжээ. Энэ бүжиг нь Бурханы шашны дайснуудыг дарахын зэрэгцээ үзэгч олонд сайн сайхныг авчрах бэлгэдэлт агуулгатай ёслол юм. Улаанбаатар хотын Зүүн хүрээ Дашчойлин хийдийн лам нар түмэн олны хүсэлд нийцсэн нууц тарнийн ёсны энэхүү зан үйлийг амжилттай сэргээн үргэлжлүүлж байна.

*Данишг* (*b t orshil*, төвдөөр *brtan bzhugs*) бол Богдод урт насыг билэгдэн бат оршил өргөх ёслол байсан бөгөөд өнөөдөр Өндөр гэгээн Занабазарын (1635-1723) дурсгалыг хүндэтгэх, хутаг хувилгаадын хойд дүрийг тодруулах зэрэг онцгой тохиолдолд үйлддэг ёслол болоод байна.

Цагаан сарын шинэ гарахаас өмнө гол сүм хийдүүдэд гурав хоногийн турш догшин бурхадыг аргадахын зэрэгцээ зовлон зүдгүүр, байгалийн гамшгийг зайлуулах зорилгоор *сор залах ёслол* (төвдөөр *zor*) үйлддэг байжээ. Шинэ жилдээ элдэв барцадгүй амар амгалан байхыг билгэдэн Балдамхлам (төвдөөр *dral ldan lha mo*, санскритаар *Ṛṇdevn*) бурханд зориулсан *Цэдэрлхам ёслол* (төвдөөр *tshes gtor lha mo*)-ыг шинэ жилийн шинийн нэгний өглөө бүх сүм хийдэд жил бүр үйлддэг байжээ. Өнөөдөр гурван өдрийн турш үргэлжлэх ёслолыг *Хуучин хурал* гэж нэрлэн онцгой тохиолдолд үйлддэг бол *Цэдэрлхам* ёслолыг жил бүрийн шинийн нэгний өглөө нийслэл Улаанбаатар хотын бүх сүм, хийдэд үйлддэг болоод байна.

Өмнө нь Бурханы шашны дөрвөн том ёслол, гэлүгва ёсны үндэслэгч Зонхов (1357-1419) болон Монголд гэлүгва ёсыг дэлгэрүүлэхэд онцгой үүрэг гүйцэтгэсэн Өндөр гэгээн Занабазарын дурсгалд зориулсан зан үйлийг Монголын бараг бүх сүм, хийдэд үйлддэг байжээ. Энэ уламжлал өнөөдөр ч

хэвээр хадгалагджээ.<sup>1</sup> Өнөөдөр *Бурхан багшийн дүйчэн өдөр* нэртэй чухал өдрүүдээр *Түвийн чого* (төвдөөр *thub pa'i cho ga*) буюу *Бурхан багшийн чого* нэртэй дөрвөн томоохон зан үйл үйлдэж байна. Зан үйл бүр нь зорилгодоо нийцсэн тусгай нэртэй. Өргөөд шинэ оны эхний 15 хоногийн туршид *Оройн Ерөөл* хурдаг байжээ (*Yerцл chenbo khural*, төвдөөр *smon lam chen mo*; буюу *Цагаан сарын дуудвий/дудвай*, төвдөөр *bstod pa*; буюу товчоор ерөөл, төвдөөр *bstod pa*; буюу *Choinprel jonaa*, төвдөөр *chos 'phrul bco lnga*). Эдгээр зан үйлийг 15 хоногийн туршид дацангуудад, мөн хөдөө орон нутгийн зарим сүм хийд, Гандан, Дамбадаржаа, Зүүн Хүрээний гол дуганд үйлддэг байна.

Бурханы шашны өөр нэг томоорхон ёслол бол зуны эхэн сарын 15-ны өдөр давхцан тохиодог Бурхын багшийн төрсөн өдөр, гэгээрэл олж Бурхан багш болсон өдөр болон түүний нирваан дүр үзүүлсэн өдрийг дурсах ёслол юм (*T. mngon par byang chub pa'i dus chen*). Бурхан багшид зориулсан гуравдах томоохон ёслол нь зуны сүүлийн сарын 4-ний өдөр тохиодог. Энэ нь Бурхан багш сургаалаа анх номлосон өдрийг дурсан Бурхан багш номын хүрд анх эргүүлсэн өдрийн ёслол гэж нэрлэдэг (*Чойнхор дүйчэн*, төвдөөр *chos 'khor dus chen*). Дээрх хоёр зан үйлийг Зүүн хүрээний гол дуганд үйлддэг байсан бололтой. Позднеев зуны адаг сарын 4-ний нэгэн өдөр *Чойнхор дүйчэн* ёслолыг үйлдэж байхыг гэрч нь болж, энэ тухайгаа тэмдэглэн үлдээсэн байдаг (1971, pp. 54-55). Дараагийн ёслол бол намрын адаг сарын 22-нд тэмдэглэдэг *Лхававын дүйчэн* буюу *ерөөл* (төвдөөр *lha las babs pa'i dus chen*) юм. Энэ бол Бурхан багш тэнгэрийн орноо 90 хоног яр

<sup>1</sup> Өнөө үеийн зан үйл, баяр ёслолын тухай нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл Г.Диваасамбуу, *Гандантэгчэнлин хийд дахин сэргэсэн түүх*. Улаанбаатар 2009; Майер С., *Монголын сүм, хийдүүдийн өнөө үеийн зан үйл, ёслолын харьцуулсан судалгаа*. Докторын зэрэг горлох диссертаци, *Өтвөш Лоранд Их сургууль, Будапешт хот, 2009* материалыг үзнэ үү.

хайлан (төвдөөр *khas len*), сургаал айлдсаны дараа хүмүүний ертөнцөд бууж ирсэн үйл явдлыг дурсах ёслол юм. Шашны сургуулиуд яг энэ өдөр *Лхававын дом* (төвдөөр *lha las babs pa'i ston mo*) уншдаг бол энэхүү номыг орон нутгийн зарим сүм дуганд бас уншдаг ажээ. Өвлийн эхэн сарын 25-ны өдөр тохиодог Богд Зонховын нирваан дүр үзүүлсэн өдөр *Богд ламын дүйчэн ерөөл*, *Богд Зонховын дүйчэн ерөөл*, *Зулын дүйчэн* уншдаг байжээ. Өнөөдөр үүнийг *Зонховын дүйчэн*, *Богд ламын дүйчэн* гэж нэрлэхийн зэрэгцээ Богд Зонховын дурсгалыг хүндэтгэн зул барьж, хүж асаадаг зан үйлээс үйдсэн *Зулын 25* нэрээр тэмдэглэж байна.

Хамгийн удаан хугацаанд үйлддэг зан үйл бол зуны адаг сарын 15-ны өдөр эхлээд 45 хоногийн турш үргэлжилдэг *хайлин* буюу *яр хайлан* (төвдөөр *dbyar, khas len*) байсан бөгөөд зуны хурал хурах энэхүү үеийг мөн *ярнай* (төвдээр *dbyar gnas* буюу зуны хурал) гэж нэрлэдэг байв. Энэхүү зан үйлд зөвхөн сахил санваартан болон шинээр сахил хүртсэн лам нар оролцох эрхтэй байсан бөгөөд энэ үеэр Винай буюу явдал мөрийн ёс цаазыг уншин, сахил санваараа давтан баталж, магадлалт алдаа дутагдлаа наминчилж, засан залруулдаг байв. Өнөөдөр энэ хуралд доод тал нь дөрвөн сахил санваартан лам оролцох ёстой. *Сожин* (төвдээр *gso sbyong*, нүглээ наминчлах, бие сэтгэлээ ариусгаж сахил санваараа батлах) нь энэ зан үйлийн нэг хэсэг болдог. Сар бүрийн 15 болон 30-ны өдөр Дамбадаржаа хийдийн гол дуганд *Сожин* хурдаг байжээ. Өнөөдөр сахил санваартай лам нар цөөн болсон шалтгаанаар *сожин* хүртээх зан үйл бүрэн сэргээгүй байна. Ганжуур эргэх (*Ganjuur, T. bka' gyur*), овоо тахих ёслолууд Өргөө орчимд өргөн үйлдэгддэг байсан бөгөөд одоо эдгээр зан үйл аажмаар сэргэж байна.

## 1937 онд үйлдэгдэж байсан болон өнөөгийн шашны зан үйлүүдийн талаарх мэдээллийн эх сурвалж

Монголын сүм, хийдүүдэд үйлдэж байсан шашны зан үйл, ёслолуудын талаарх мэдээллийн эх сурвалж нэн ховор. Харин Монголын Үндэсний төв архивт Өргөөд үйл ажиллагаа явуулж байсан гэлүгва ёсны 28 сүмд үйлдэж байсан зан үйлүүдийн жагсаалтууд хадгалагдаж байна.<sup>1</sup> Эдгээр жагсаалтыг 1937 онд Шашны захиргааны тушаал шийдвэрээр бичиж үлдээсэн бөгөөд үүнд зан үйлийн нэр, тэмдэглэх сар өдөр, үргэлжлэх хугацаа, шаардлагатай лам нарын тоо болон тухайн он, түүнээс өмнө үйлдсэн 623 ёслол, зан үйлд оролцсон лам нарын нэр зэрэг багтжээ. Эдгээр үнэт сурвалж бичиг нь сүм, хийдүүдийг хааж нураахаас өмнө аль хийд хэдэн ламтай байсныг тодорхой харуулахын зэрэгцээ сүм, хийдүүдэд шашны амьдрал идэвхтэй өрнөж байсныг баталж байгаагаараа тун онцгой эх сурвалж юм. Бидний л мэдэж байгаагаар, ийм түүхэн баримтат сурвалж бичиг Улаанбаатар хотын 300 гаруй жилийн түүхэнд тун ховор юм.

28 сүм, хийдэд хамаарах мэдээллийн дотор Гандангийн гол дуган (*Гандантэгчэнлин*), шүтээний гурван сүм (нийт 31 зан үйл), Гунгаачойлин дацан (42 зан үйл) болон Идгаачойзинлин дацан (35) нэртэй гүн ухааны хоёр сургууль; *Хайлан жас* (3); Зүүн хүрээний маарамбын сургууль (17) болон Зүүн хүрээний 22 *аймгийн*<sup>2</sup> хийдүүд, үүний дотор *Жадар* (10), *Тойсамлин* (23), *Цэцэн тойн* (23), *Дашидандарлин* (17), *Жас* (20), *Номч* (15), *Сангай* (16), *Зоогой* (29), *Дугар* (14), *Мэргэн хамба* (12), *Бизъяа* (11), *Хүүхэн ноён* (10), *Дархан эмч* (16), *Эрхэм тойн* (23), *Вангай* (48), *Барга* (7), *Намдоллин* (26), *Бандад* (13), *Жамъянсүн / Чойнсүн* (25), *Лам нар* (17), *Мэргэн номон хан* (15), *Өрлүүд* (25) хийдүүдийн дүрслэл,

<sup>1</sup> Эх бичвэрүүдийн гарчгийг Номзүй хэсгээс үзнэ үү.

<sup>2</sup> Зүүн Хүрээ 30 аймаг (лам нарын амьдардаг дүүрэг)-тай байсан бөгөөд аймаг бүр нь өөрийн сүмтэй байжээ.

мөн Дамбадаржаа хийдэд (90) үйлдэж байсан ёслолуудыг бичиж үлдээсэн байдаг. Эдгээр мэдээлэл нь нийслэл хотод гэлүгва ёсны шашны амьдрал маш баялаг, идэвхтэй байсныг гэрчилнэ. Одоо эдгээр ёслолын заримыг жишээ болгон сийрүүлж толилуулъя.

Өдөр тутмын зан үйлээс нэрлэх юм бол, сүмүүдийн гол дуганд *цогчин* (Т. *tshogs chen*) хурал, харин бусад сүм, дуганд цөөн хэдэн лам *жасаа хурал* тогтмол хурдаг байжээ. (*жасаа* гэж түр буюу ээлжийн хурал, гэр бүлийн зан үйл, эсвэл тогтмол үйлддэг зан үйлийг хэлнэ). Өнөөдөр *цогчин хурал* хаа сайгүй сэргэж, томоохон сүм хийдэд сүсэгтэн олны хүсэлт захиалгаар дөрвөн лам өдөр бүр ном уншиж хэвшжээ. Өргөөгийн хэд хэдэн хийдэд *Жасаа сахиус*, *Жасаа цэдэв* болон тухайн хийдийн хэвшсэн заншилд нийцсэн жасаа зан үйлийг хос лам (хоёр, дөрөв, найман лам гэх мэт) өдөр бүр гүйцэтгэдэг байжээ. *Сан тавих* (төвдөөр *bsangs*) буюу арц хүж уугиулж ариутган утах ёслол хэд хэдэн сүм хийдэд өдөр бүр үйлдэгддэг байсан бөгөөд зарим тохиолдолд *даллага авах* (төвдээр *g.yang gugs*, эд баялгын хүчнүүдийг дуудан хуруулах) зан үйлтэй хамт хийдэг байв. Зарим сүм хийдэд *Намсрайн сан* (төвдөөр *rnam sras bsangs*), *Майдарын сан* зэргийг өдөр бүр уншихдаа ихэнхдээ тавгийн идээтэй (*dorbul*, Т. *gtor 'bul*), дэмбэрэл (Т. *rten 'brel*) уншдаг байжээ. Эдгээр зан үйл өнөөдөр ч хэвээр хадгалагдаж байна.

Будда Шакьяамуни, Богд Зонховоос гадна монголчууд мөн найман Богд зэрэг шашны тэргүүнүүдээ дээлэн шүтэж, жил бүр дурсгалыг нь хүндэтгэдэг. Ийм төрлийн *дүйчэн ерөөл* (төвдөөр *dus chen*, ‘их өдөр, баяр’, мөн даичид, дайчод ерөөл буюу төвдөөр Т. *‘das mchod*, ‘нирваан дүр үзүүлсний ой, дурсамж) хэмээх ёслолууд нь сүм, хийд болгонд үйлдэгддэг байжээ. Сурвалж бичгүүдэд хоёр ч нэр томъёог нэгэн зэрэг хэрэглэсэн байдаг. Эдгээр зан үйл нь ерөөл магтаалын утга агуулгатай байдаг. Монгол гэгээнтэн, хутагтуудын тухайд бол



хаврын эхэн сарын 14-ний өдөр *Өндөр гэгээн Занабазарын их дүйчэн* өдөр тохиодог бөгөөд энэ өдөр *Өндөр Богдын дүйчэн ерөөл*, эсвэл *Өндөр гэгээний дүйчэн ерөөл*, *Цагаан сарын 14-ний ерөөл*, *Цагаан сарын ерөөл*, заримдаа зүгээр л *ерөөл* гэж нэрлэдэг ёслол үйлддэг. Лам нар Өндөр гэгээний их үйлс, жанч халсан үйл явдлыг дурсахын зэрэгцээ түүний хойд дүрүүдийг мөн хүндэтгэн ёсолж байжээ.<sup>1</sup> 2 дугаар *Богдын дүйчэн ерөөлийг* өвлийн сүүл сарын 17-ны өдөр уншдаг байжээ. Өндөр гэгээний гуравдах дүрийн дурсгалд зориулж намрын адаг сарын 21-ний өдөр, 4 дүгээр Богдод зориулж өвлийн дунд сарын 16-нд ном хурдаг байжээ. 5 дугаар Богдын дурсгалыг өвлийн эхэн сарын 3-ны өдөр хүндэтгэдэг бол 6 дугаар Богдын дурсгалд зориулж өвлийн эхэн сарын 20-ний өдөр, 7 дугаар Богдын гэгээн дурсгалыг хүндэтгэж өвлийн дунд сарын 12-ны өдөр ном хурдаг байжээ. Эдгээр ёслолыг зөвхөн *Вангайн* болон *Лам нарын* аймгийн сүм хийдүүдэд үйлддэг байсан нь бол 8 дугаар Богдын дурсгалд зориулсан ёслолыг хэд хэдэн хийдэд өвлийн эхэн сарын 17-ны өдөр үйлддэг байжээ.

Өнөөдөр бол зөвхөн Өндөр гэгээний дурсгалд зориулж хаврын эхэн сарын 14-нд маань ерөөл хөгжөөж байгаа бол бусад гэгээнтэнтэй холбоотой зан үйлүүд мартагдаад байна.<sup>2</sup> Цаашилбал, дээрхээс бусад гэгээнтнүүдийг дурсан зарим сүм хийдэд ном хурж байсны нэг жишээ нь *Сүнгийн аймгийн* сүм, хийдэд үйлдэж байсан *Хачин ламын* (төвдөөр *mkhan chen bla ma*) дурсгалд зориулж өвлийн дунд сарын 7-нд ном хурдаг байсан явдал юм. *Жалханз хутагтын* (төвдөөр *rgyal khang rtse*, Бурханы шашны нөлөө бүхий гэгээнтнүүдийн Монгол угсааны хойт дүрийн нэг) дурсгалыг хүндэтгэх

<sup>1</sup> Өнөөдөр энэ зан үйлийг *Давхар ерөөл* гэж нэрлэх болсон нь энэ өдөр Цагааны сарын шинийн 15-ны өдрийн ном, хурлын зэрэгцээ Өндөр гэгээнийг дурсан зан үйлүүдийг давхар үйлдэх утга санааг илэрхийлнэ.

<sup>2</sup> Өнөө цагт Ганданд энэ өдөр Уулын лам Лувсангийн (төвдөөр *blo bzang*) 8 дугаар Богдод зориулж бүтээсэн *Уулын ламын чоги* номыг уншдаг заншил тогтоод байна.

ёслолыг *Вангайн аймгийн* сүм хийдүүд зуны дунд сарын 9-ний өдөр үйлддэг байсан бол *Ёнзон хамбыг* дурсах ёслолыг *Вангайн болон Эрхэм тойн аймгийн* сүм, хийдүүдэд өвлийн дунд сарын 7-ны өдөр үйлдэж байжээ. 8 дугаар Богд буюу Богд хааны (1870-1924) дурсгалыг хүндэтгэн хэд хэдэн сүм, хийдэд ном хурдаг байжээ. Өнөөдөр бол энэ ёслолыг зөвхөн Ганданд үйлдэж байна.

Догшин сахиусуудыг тахих утгатай зан үйлүүдийн жилийн тодорхой өдрүүдэд үйлддэг байжээ. Сүм бүр ивээгч ядам бурхан (*yadam*, Т. *yi dam*), хамгаалагч сахиусынхаа сэрэг дүр, ном судрыг сүмдээ залдаг байв. Өнөөдөр сар бүрийн 29-ний өдөр *Сахиус* буюу *Хангал* уншиж, ивээгч, хамгаалагч бурхаддаа тахил өргөдөг заншилтай болоод байна. Өргөө хотод эдгээр бурхан, сахиусыг шүтэн дээдлэх янз бүрийн зан үйл үйлддэг байсны дотор, жишээлбэл, догшин сахиусуудад зориулсан *Арван хангал* номыг нэрлэж болно. Энэ номыг хамаг амьтны тусын тулд, лам хуврагуудыг аливаа ад зэтгэрээс хамгаалах зорилгоор уншдаг байна.

Зан үйлийг 9 *хангал*, 6 *хангал*, эсвэл *Лхам*, *Гомбо*, *Гонгор*, *Намсрай* зэрэг тодорхой нэг юмуу хоёр сахиусанд тусгайлан зориулж үйлдэх нь бий. Заримдаа *Сахиус данрагт*, *Хангалын данрагт* зэрэг зан үйлийн үеэр сахиус, бурхадад зориулан талархлын өргөл (*данраг*, төвдөөр *gtang rag*) өргөх, заримдаа дүгжүү өргөлийн (төвдөөр *drug bcu*) хамтаар өргөл барьдаг байжээ. Эдгээрийн дотроос *Чойжал дүгжүү* буюу *Чойжоо дүгжүү* нь Чойжал бурханд (Эрлэг Номун хаан буюу монголчуудын дунд Чойжоо бурхан гэж нэрлэгддэг, төвдөөр *chos rgyal*, санскритаар Yama) зориулсан урьд, өнөөгийн хамгийн алдартай зан үйл юм. Догшин сахиусуудад зориулсан нэгэн чухал ёслол бол өвлийн дунд сард 3-4 өдрийн туршид үргэлжилдэг *Даншигийн хангал* (төвдөөр *brtan bzhugs*) бөгөөд энэ номыг Өргөө хотын хэд хэдэн аймагт хурдаг байжээ. Цаашилбал, *Дэргэдийн хангал* (хамгаалагч дэд тэнгэр(?)) зан

үйлийг зарим аймаг ёслол гүйцэтгэдэг байв. *Түмэд хангал* буюу *Түмэд сахиус* нэртэй хамгаалагч тэнгэрүүдэд зориулсан өөр нэгэн төрлийн зан үйлийг *Гунгаачойлин дацан* үйлддэг байсан нь архивын материалаар батлагддаг юм. Бараг л бүх сүм, хийд өөр өөрийн ивээгч тэнгэрийн ивээсэн өдөр, эсвэл дотоод заншилдаа нийцүүлэн сонгож авсан өдрүүдээр *Их сахиус* ном хурдаг байсан тухай мэдээлэл бий.

Энэрэл нигүүлсэлийн бурхан Арьяавал (*Avalokitesvara*), аврагч бурхан Дарь эх зэрэг ивээгч тэнгэрт (голлон Бурхан багш, бодьсатванууд) зориулж лам нар хэд хэдэн зан үйл үйлддэг байжээ. Зарим сүмд өөрийн ивээгч бурханд зориулж элсээр мандал (*дүлцэн*, төвдөөр *rdul tshon*) босгодог байв. Өнөөдөр жил бүр зөвхөн хотол мандлыг (*Kālacakra maṅgalas*) Гандан хийдэд босгож байна. *Чого* (төвдөөр *cho ga*) буюу ‘зан үйл, ёслол, тогтсон горимын дагуу хийх үйлдэл’ гэсэн утгатай үг нь гол төлөв Бурхан багш, бодьсатва болон бусад ивээгч тэнгэрт зориулан үйлддэг томоохон ёслолуудын нийтлэг нэр юм. Эдгээр зан үйлийг гүйцэтгэхдээ эхлээд абшиг авахуулаад, дараа нь тухайн бурханд зориулсан тусгай зан үйлүүдийг тодорхой дарааллаар хийдэг байна. Бурхадад зориулсан зан үйлийн заримаас нэрлэвэл, өөрийн болон бусад хүний бүхий л нүглийг арилгаж энэ насандаа амар амгалан амьдарч, хойт төрөлдөө Диваажингийн оронд төрөхийн төлөө залбирах *Авидын чого*, цаглашгүй их нас бэлэглэгч Аминдаваа буюу Аюуш бурханыг сүслэн дээдэлсэн *Аюушийн чого* зэрэг болно. Бодьсатва нарт зориулсан зан үйлүүдээс нэрлэвэл, дарь эхүүдийг дээдлэн хүндэтгэсэн утгатай *Дарь эхийн чого*, Авалокитешвара буюу Жанрайсаг бурханд зориулсан *Жанрайсэгийн чого* (төвдөөр *spyau ras gzigs kyi cho ga*) зэрэг ном хурдаг. Мөн Бурхан багшийн шавь 16 архадад зориулан *Найдан чого* хурдаг байсан нь өнөөдөр сар бүрийн 30-ны өдөр тогтмол хурж хэвшээд байна.

Дээр дурьдсан ёслолуудын хажуугаар шашны өөр олон зан үйл, баяр ёслол байсан нь эх сурвалжуудад тэмдэглэгдэн үлджээ. Үе үе цөөн хэдэн лам *нуннай/ нүгнэ/ нүгнэй* буюу мацаг барьдаг байжээ (төвдөөр. *stuyung gnas*, 'мацаг барих зан үйл'). Энэ нь 3-15 хоногийн турш мацаг барих зан үйл бөгөөд чингэхдээ Авалокитешвара буюу Жанрайсаг, Важрапани буюу Очирваань, Акшоба (*Минтүгва ядамын нуннай*) юмуу Оточ Манал (*Маналын нуннай*) бурханд сүслэн залбирдаг байна. Зарим газар үүнээс гадна *Дөрвөн цагийн нуннай* (улирлын мацаг) болон *Жасаа нуннай* үйлддэг байжээ. Өнөө цагт лам нар өөрийн хүсэл зоригоор ганцаар мацаг барьж болно. *Жасын галын тахилга* нэртэй гал тахих ёслолыг бараг л бүх сүм, хийдэд өвлийн адаг сарын 24, 25 юмуу 26-нд тусгайлан томилсон 2-4 лам үйлддэг байв. Энэ зан үйл нь сүм, дуган, хийд газрын эд хөрөнгө, сан хөмрөг, аж ахуйг хариуцдаг жасыг ариутгах утгатай юм.

Зуны сүүл сарын 25-ны өдөр *Дашнямын аравнай* (төвдөөр *bkra shis nyi ta rab gnas*) нэртэй зан үйлийг Вангайн аймаг ёслон үйлддэг байжээ. Өнөөдөр энэ зан үйлийг *Их аравнай* нэрээр гүйцэтгэж байгаа бөгөөд энэ өдөр шүтлэг бишрэлийн бүх эд зүйл, бурхан, тахил, бурханы хөрөг зураг зэргийг Ганданд дахин ариусган аравнайлж, анхны аравнайлах ёслолын үр нөлөөг сэргээх ёслол хийдэг байна.

*Хажид* (төвдөөр *mkha' spyod*)-ыг тусгайлан томилогдсон 4 лам 5 дугаар Богдын шарилын дацанд сар бүрийн 10-ны өдөр уншдаг байжээ. Өнөөдөр Гандан зэрэг Монголын цөөн хэдэн хийдэд жилд нэг удаа *Хажидын чога* уншдаг болоод байна. Гэхдээ ялангуяа Улааны ёсны зарим нэг хийдэд энэ ёслолыг сар бүрийн 10, 25-ны өдрүүдэд үйлдэж байна. 5 дугаар Богд өөрөө *Нархажид* (төвдөөр *na ro mkha' spyod*, санскритаар Sarvabuddha dākinī) бурханы авшиг увидас хүртсэн хувраг байжээ. Нархажид бурханд сүслэн бясалгаж суухдаа тэрээр Богд уул, Туул голын дээгүүр улаан

гэгээ татахыг харсан гэдэг яриа байдаг. Улмаар энэ ёслолыг тэр үеэс үйлддэг болжээ.

*Тарнийн ёсны үндэс* (төвдөөр *rgyud*, дандар буюу нууц тарнийн ёс) зан үйлийг зөвхөн ивээгч тэнгэрт зориулан үйлдээд зогсохгүй мөн Дарь эх, бусад бурхадад зориулдаг байсан бөгөөд идээ боовоор (*дордов*, төвдөөр *gtor sgrub*) өргөл барьдаг ёсон байжээ (жишээлбэл, *Гүргүлийн дордов*). *Гүнрэг* (*Гүнрэг Намбарнанзад* гэдгийн товч нэр, төвдөөр *kuṅ rig(s) rnam par snang mdzad*, санскритаар Sarvavidyā Vairocana) нэртэй нөгчигсөдөд зориулсан зан үйлийг хувь хүмүүсийн хүсэлтээр тогтмол үйлддэг байжээ.

Тойсамлин аймагт сар бүрийн 15-ны өдөр *Гухяасамажа* буюу *Сандуйн Жүд* (төвдөөр *gsang 'dus rgyud*) уншдаг байв. Өнөө үед бараг бүх сүм, хийдэд энэ өдөр Сандуйн Жүд уншиж байна (Гандангийн лам нар хуучин Жүд дацанд тогтоосон дэг жаягийг хэвээр хадгалан үлджээ). Эх сурвалжуудад тэмдэглэснээр 1937 оноос өмнө Гандантэгчэлин хийдэд *Сандуйг* монгол хэл дээр уншсан тухай эх сурвалжуудад тэмдэглэсэн байдаг.

*Бумбын тахилга* нэртэй тусгай ёслолуудыг зарим хийдэд үйлддэг байсан бөгөөд эдгээр нь *Гонгорын бумба*, *Намсрайн бумба*, *Жамбалын бумба*, *Маналын бумба* зэрэг болно. *Ганжуурыг* цөөн хэдэн сүм хийдэд хааяа нэг хурдаг байсан байна.<sup>1</sup> *Цогчид өргөх*, *Цогчид* зан үйлийг (төвдөөр *tshogs mchod*, санскритаар gaṅarījā, ‘өргөлийн цогц’, идээ өргөх) ивээгч бурхадад зориулан үйлддэг байжээ. *Дончид* (төвдөөр *stong mchod*, ‘мянга дахин үржих өргөл’) нэртэй зан үйлийг хэд хэдэн бурханд зориулан үйлдэж байв. *Бүтээл* гэдэг нь тодорхой бурхны зүрхэн тарнийг давтан уншиж хөгжөөхийг хэлнэ. Шашны гүн ухааны сургуулиудад *Мэгзэмийн бүтээл* (төвдөөр *dmigs rtse ma*) болон *Жанрайсэгийн бүтээлийг* зуны

<sup>1</sup> Өнөө цагт *Жасаа Их Ганжуур* буюу *Алтан Ганжуурыг* зөвхөн Ганданд зуны адаг сарын 5-нд жилдээ нэг удаа хурж байна.

дунд сард зургаан өдрийн турш хэдэн зуун лам оролцон уншдаг байсан бол зарим сүм хийдэд цөөн хэдэн лам нэг, хоёр өдөр уншдаг байжээ. Өнөөдөр энэ зан үйлийг *Маанийн бүтээл* гэж нэрлэдэг болжээ. Энэ номыг *Жанрайсэг* бурханд зориулан эрүүл, амар амгалан амьдралыг хүсэмжлэн уншдаг. Өргөөд *Дарь эхийн бүтээл*, *Чойжингийн бүтээл*, *Гүргүүлийн бүтээл* мөн уншдаг байжээ. Оточ Маналд зориулсан зан үйлүүдийг гол төлөв шашны анагаах ухааны сургуулиуд үйлддэг бөгөөд Манал бурханд зориулсан хэд хэдэн зан үйл байдаг.

*Гүрэм* (төвдөөр *sku rim*) болон өнөөдөр засал гэж нэрлэгддэн зан үйлүүд нь өвчин эмгэгээс анагаах, сэргийлэн хамгаалах зорилгоор уншдаг ном юм. *Гүнрэг* нь хамаг амьтныг муу төрөлд төрөхөөс авран, төрөх ахиулах, үл зохих төрөлд дахин төрөхөөс аврах зорилготой. Дугарын аймагт *Жадамба* (төвдөөр *brgyad stong pa*, Хоосон чанарын сургуулийн найман мянган мөрт хураангуй) уншдаг байжээ.

Шашны гүн ухааны сургуулиуд өвлийн саруудад хэдэн төрлийн *дом* (төвдөөр *sdom*) барьдаг байсан нь дөрвөн их дом, дөрвөн бага дом юм. Эдгээр ёслол нь үйлдэгддэг өдрөөрөө нэрлэгдэн *18-ний дом*, *19-ний дом*, *20-ны дом*, *21-ний дом*, *25-ны дом* нэртэй болжээ. Эдгээрийн ихэнхийг Бурхан багшийн их дүйчэн өдрөөр үйлддэг байжээ. Цаашилбал, *Гавжийн дамжаа* (төвдөөр *dka' bcu'i dam bca'*), (*Парчин*) *Домын дамжаа* (төвдөөр *phar phyin ston mo'i dam bca'*) зан үйл үйлдэхийн зэрэгцээ гүн ухааны таван ботиор ном хаялцдаг байв (Таван боть буюу *Даж эргэх*). *Жороо*,<sup>1</sup> *Жүшийн /зүшийн дом* (төвдөөр *bcu bzhi*), *Лхававын дүйчэн ерөөл* буюу *Лхававын дом* зэрэг зан үйл үйлддэг байсан тухай эх сурвалжуудад дурьджээ. Сонинбаярын<sup>2</sup> тэмдэглэснээр

<sup>1</sup> Утга санаа нь бүрэн мэдэгдэхгүй байгаа. Монголоор *Жороо*, төвдөөр ?

<sup>2</sup> Ш. Сонинбаяр (редактор), Гандантэгчинлэн хийд, Шашны дээд сургуулийн хураангуй түүх. Цагаан лавайн дуун эгшиг хэмээх оршвой. Улаанбаатар 1995, 66-67 дугаар нүүр.

дом барих буюу домын дамжаа барихын өмнө домын эрдэмд суралцсан лам нар дөрвөн их дом, гурван бага домын ёслолд оролцох ёстой байжээ.<sup>3</sup> Өнөөдөр гүн ухааны шалгалт, дамжааг зөвхөн Гандан хийдийн Дашчоймбол хийдэд барих боломжтой болсон байна.

Зарим сүм, хийдэд *Намрын дунд сарын хурал*, *Хаврын сүүл сарын хурал*, *Өвлийн тэргүүн сарын хурал*, *Өвлийн дунд сарын хурал*, *Өвлийн тэргүүн сарын 25-ний ерөөл*, *Арван тавны дангар*, *сарын чого* буюу *сарын хурал*, *Намрын нэг сарын хурал* гэх мэт улирлын утга холбогдолтой хурал ном хурдаг байжээ.

Архивын эх сурвалжуудад Нимава ёсны буюу улааны урсгалын хийд, дацангуудын талаар мэдээлэл бараг үлдээгүй ч тэдгээр нь Бадмасамбава буюу Бадамжунай ловон, дагинасыг шүтэн, улмаар тэдэнд зориулж сар бүрийн 10 болон 25-нд хурал ном хурдаг одоо үйл ажиллагаа явуулж буй улааны урсгалын 10 орчим сүм, хийдтэй ижил төстэй зан үйлтэй байсан бол уу гэж таамаглаж болох юм.

### **Сүсэгтэн олонтой харилцах нь**

Энэ чухал асуудал архивын эх сурвалжуудад огт дурьдагддаггүй тул мэдээлэл тун бага байна. 1930-аад оны сүүлээр лам нарыг үй олноор нь хомроглон усгахаас өмнө нийслэл хотын сүм, хийдүүдэд шашны амьдрал идэвхтэй өрнөж байсныг бид архивын материалуудаас харж болох бол 1990-ээд оноос хойш шашин шүтлэг сэргэж байгааг бид өөрсдийн биеэр харж, гэрч нь болж байна. Бурханы шашныг сэргээхэд сэтгэл зүрхээ зориулсан өндөр нас зооглож буй лам

<sup>3</sup> Сонинбаярын мэдээллээр бол дөрвөн их ёслол нь дараах болно: Бурхан багш номын хүүрдийг анх эргүүлсэн өдрийг тэмдэглэн зуны адаг сарын 4-нд тэмдэглэдэг *Лянх дом*; намрын адаг сарын 22-нд тэмдэглэдэг *22-ний дом*; Богд Зонховыг дурсах зорилгоор нирваан дүр үзүүлсэн өдрөөр нь жил үйлддэг *25-ний дом*, мөн өвлийн дунд сарын 14-нд үйлддэг *Жүшийн дом*.

нар, үнэнч сүсэгтнүүдийн ачаар бид өнөөдөр Майдар эргэх ёслол, цам бүжиг зэрэг олон зан үйлийг дахин үзэх боломжтой болоод байгаа билээ. Өнөөдөр сүм, хийдүүд уламжлалаа хадгалахын зэрэгцээ зан үйлүүдээ хөгжүүлэн баяжуулж байгааг харж байна. Сүм, хийдүүд олон төрлийн шашны зан үйлийг сэргээн гүйцэтгэх болсны хажуугаар сүсэгтэн олны өдөр тутмын амьдрал, зан үйлийг дэмжих үүднээс лам нар олон чиглэлээр хичээн ажиллаж байгааг заавал дурьдах хэрэгтэй. Сүүлийн хэдэн жилд Улаанбаатар хотод лам нарын нэр хүнд, тоо буурч байгаа бол хөдөө аймаг сумандаа үлдэн, үйл ажиллагаа явуулж буй лам нар орон нутагт Бурханы шашныг сэргээх, сум орон нутгийн сайн сайхныг бэхжүүлэн бататгахад маш их хувь нэмэр оруулж байгаа нь анзаарагдаж байна. Лам нар гэртээ бясалгал үйлдэн, абшиг хүртэж, шашны ном сургааль сонсож, одоо энэ ертөнцөд байхгүй багш нараасаа анх өвлөн авсан эрдэм ухаанаа улан арвидуулан хөгжүүлэх боломжтой. Харин сүсэгтэн олон сүм хийдэд очин, лам нарт өргөл, барьц өргөх, буян хийх, мөргөн залбирах, тагтаа шувуу хооллох, зул өргөх, маань унших, хүрд эргүүлэх зэрэг олон зан үйлээр өөрийн сэтгэл санааг ариусгаж, бурхандаа талархал илэрхийлэх боломжтой юм. Лам, сүсэгтнүүд хамтран овоо тахин, суварга босгож байна. Сүсэгтний хүсэлтээр лам нар гэрт нь очиж өвчин зовлон, саад тотгор, дайрлагаас сэргийлэх, ангижруулах ёслол гүйцэтгэж өгдөг. Лам нар мөн элбэг дэлбэг амьдрал ерөөж сүсэгтний шинэ гэр, сууцанд ном уншихаас гадна өөрсдийг нь хамгаалах бэлгэдлийн эд зүйлсийг аравнайлан шүншиглэх, хурим хийх, нүүж суух зэрэг өдөр тутмын амьдралын олон асуудлаар зөвөлгөө өгдөг байна.

Хэдийгээр хөдөө орон нутагт шашны зан үйлүүд нь Улаанбаатар хот шиг өргөн дэлгэр хэмжээнд сэргээгүй ч хөдөөд лам нарын дэг жаяг хотынхоос ялгаагүйн дээр нэр хүнд нь илүү байна. Өдөр тутмын ном уншлагаас бусад зан



үйл, ёслолыг сэргээж чадаагүй байгаа хөдөө орон нутгийн лам нар байнгын орлого байхгүй, татвар төлөх ёстой зэргээс болж шавь нараа ном ёсоор сайн сургаж чадахгүй, сүм хийдийнхээ хаалгыг барьчихгүйн төлөө л ажиллаж байна.

Сүм, хийдүүдийн хоорондын хамтын ажиллагаа тодорхой, хязгаарлагдмал хүрээн сэргэж байгаа нь шашны зан үйлүүдийг сэргээн хөгжүүлэхэд хангалттай харагдаж байна. 20 дугаар зууны эхээр Монгол, Төвдийн лам нар нийслэл хотоос хөдөө орон нутгийн сүм, хийдүүдэд богино хугацаагаар айлчлан, ном сургууль айлдан, хэвшиж буй буй зан үйл, үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж байжээ. Энэ уламжлал өнөөдөр нь үргэлжилж байгаа ч хааяа л нэг болж байгаа нь үнэн. Сүүлийн хэдхэн жилд хутагт хувилгаадын хойд дүрийг тодруулах уламжлал сэргэсэн нь сүсэгтэн олон, ард нийтийн итгэл үнэмшлийг дэмжихэд томоохон нэмэр болж байна. Дүгнэн хэлэхэд, лам нарын тоо цөөн тул хуучин гүйцэтгэж байсан бүх зан үйл, ном уншлагыг бүрэн сэргээх боломжгүй тул шашны уламжлалт зан үйлүүдийг алхам алхмаар аажуу сэргээх хэрэгтэй юм.

## Ном зүй

- Г. Диваасамбаа. *Гандантэгчэнлин хийд дахин сэргэсэн түүх*. Улаанбаатар 2009 [History of the Revival of Gandantegchenlin Monastery]
- Б. Жамбал, Д. Мөнхсайхан. *Цогчин уншлагын зэрэг тус амгалан гарахын орон оршвой*. Улаанбаатар 2004
- Majer Zs., *A Comparative Study of the Ceremonial Practice in Present-day Mongolian Monasteries*. PhD thesis, Eötvös Loránd University, Budapest 2009
- Pozdneyev, A. M., *Mongolia and the Mongols*, edited by Krueger, J. R., translated by Shaw, J. R. and Plank, D., Bloomington, Indiana University 1971
- Pozdneyev, A.M., *Religion and Ritual in Society: Lamaist*

*Buddhism in late 19th-century Mongolia.* ed.: Krueger, J.R. The Mongolia Society. Bloomington 1978

- Soninbayar, Sh. (ed.), *Gandantegchinlen khiid, Shashnii deed surguuliin khurangui tüükh Tsagaan lawain duun egshig khemeekh orshiwoi.* Ulaanbaatar 1995 [Gandantegchinlen Monastery, Short History of the Religious College: The melody of the White Conch Shell.]
- Teleki K.: *Bogdiin Khüree: Monasteries and Temples of the Mongolian Monastic Capital (1651-1938).* PhD thesis, Eötvös Lorënd University, Budapest 2009

[www.mongoliantemples.net/English](http://www.mongoliantemples.net/English)

Монголын Үндэсний Төв Архивын эх сурвалжууд, орчин үеийн материалууд

(үг үсэг, найруулгыг хэвээр хадгаллаа)

Kh193/42	нэргүй [Шашны анагаах ухааны сургуулийн жилийн зан үйлүүд]
Kh196/8	Гандантэгчинлингийн данс [Gandantegchinling-yin dangsa]
Kh199/55	Барга аймгийн тогтмол хурлууд [Barᠠ-a-yin ayimaᠭ-un toᠭtamal qural-ud]
Kh200/21	Вангай аймгийн хурлууд нэрсийн бүртгэл данс [Wanggai ayimaᠭ-un qural-ud nersiin бүртгэл данс]
Kh208/73	Дугарын аймгийн нэгэн жилд тогтмол хурдаг хурлыг тодорхойлсон хүснэгт [Duᠭar-yin ayimaᠭ-un nigen ᠵil-dь toᠭtamal qurday qural-yi todorqailaysan кьсьньгьт]
Kh211/18	ᠵamyangsüren-yin ayimaᠭ-un nigen ᠵilün toᠭtamal qural-ud-un neres [Name of regular ceremonies held in <i>Jamiyaansürenᠵiin aimag</i> ]
Kh216/44	Toyisamling ayimaᠭ-un бүкүй qural-un dangsa [List of all ceremonies of <i>Toisamling aimag</i> ]

- Kh218/18 Мэргэн хамбын аймгийн хурлын уншлагын данс [Mergen q.ambu-yin ayimaу-un qural-un ungsily-a-un dangsa]
- Kh224/9 Өрлөгүүл аймгийн 37 оны тогтмол хурлын бүртгэл [Örligüd-ün ayimaу-yin 37 on-u toytamal qural-un bürgüdel-e]
- Kh240/1/2 37 оны Дамбадаржаа хийдийн тогтмол хурлын данс [37 on-u Dambadarijiya keyid-ün toytomal qural-un dangsa]
- SKh188/144 Гунгаачойлин дацангийн нэг жилд хурдаг хурлын нэрсийг тодорхойлсон данс [Güngaa-choilin datsangiin neg jild khurdag khurliin nersiig todorkhoilson dans]
- SKh189/2 Идгаачойжинлин дацангийн нэгэн жилийн тогтмол хурдаг хурлын хүснэгт [Yidga. çoijingling daçan-un nigen jilün toytamal quriday qural-un küsünüg-tü:]
- SKh209/66 Зоогой аймгийн тогтмол хурлын данс [ᠵоогай ayimaу-un toytamal qural-un dangsa]
- SKh212/38 Намдоллин аймгийн тогтиол хурлууд [Namdolling ayimaу-un toytamal qural-ud]
- TsKh227/48 нэргүй [Эрхэм тойний аймгийн тогтмол хурлууд]